

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
4 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-25
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	26-107
	1.Монгол Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэх	29-60
	2.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	60-74
	3.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	74-79
	4.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	79-85
	5.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	85-98
	6.Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	98-102
	7.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	102-103
	8.Монгол Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэх /үргэлжлэв/	103-107

Хураангуй тэмдэглэл

Өргөн барьсан хуулийн төслүүдийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас 2021.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./12:12/

Хоёр.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын шинжээч Д.Цолмон, ахлах мэргэжилтэн А.Амармөрөн, Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, мөн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Монголын оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал У.Тамир, Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одгэрэл, Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн Д.Нэргүй нар цахимаар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан 12 цаг 13 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ч.Ундрэм, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “мэдээллийг” гэсний дараа “хуульд заасны дагуу” гэж нэмж, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын “энэ хуулийн 4.1.7-д заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх этгээдийг/ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.5-д заасан радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийг;” гэснийг, мөн зүйлийн 4.1.27 дахь заалтын “хиймэл дагуул” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4.1.28 дахь заалтын “зохиогч, эрх эзэмшигчийн” гэснийг “зохиогч, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 29
Бүгд: 67
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтын “эзэмших” гэснийг “ашиглах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 28
Бүгд: 66
57.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2.төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн шийдвэр, албан бичиг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 29
Бүгд: 66
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “энэ хуулийн дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтын “нэгдэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёрт талт олон улсын гэрээ байгуулсан” гэснийг “олон улсын гэрээний гишүүн” гэж, 8.1.5 дахь заалтын “тус” гэснийг “Монгол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 26
Бүгд: 66
60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Бүтээл ашиглах” гэснийг “Зохиогчийн эд хөрөнгийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.1 дэх хэсэг нэмэх:

“13.1.Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах эд хөрөнгийн онцгой эрх /цаашид “бүтээл ашиглах онцгой эрх” гэнэ/ эдэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 25
Бүгд: 66
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.2 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1-д” гэснийг “13.2-т” гэж өөрчлөх:

“13.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд дараах эрхийг хамааруулна:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 25
Бүгд: 66
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа

“14.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан, эсхүл нийтэлсэн өдрөөс эхлэн тооцно.

14.2.Зохиогчийн амины эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

14.3.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.4.Хавсарга урлагийн бүтээл ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвиснаас хойш 25 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.5.Зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан бүтээлийн зохиогч нь өөрийгөө ил болгосон, эсхүл бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг энэ хуулийн 14.3-т зааснаар тооцно.

14.7.Хамтын бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.8.Албан үүргийн дагуу бүтээл туурвих, эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна. Хэрэв бүтээлийг туурвиснаас хойш 30 жилийн хугацаанд нийтлээгүй бол бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл туурвиснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	40
Татгалзсан:	26
Бүгд:	66

60.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хасаж, 14.6 дахь хэсгийн “14.5-д” гэснийг “14.4-т” гэж өөрчлөх гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 15.6 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн хэсгийн “15.5-д” гэснийг “15.6-д” гэж өөрчлөх:

“15.5.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн эрх залгамжлагч тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	26
Бүгд:	67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Энэ хуулийн 13.2-т заасан эрхийг хуульд заасан болон бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	41
Татгалзсан:	26
Бүгд:	67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсгийг нэмэх:

“17.4.Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг үүсмэл бүтээл туурвисан зохиогч эдэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 26
Бүгд: 67
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “, эсхүл захиалагч” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 27
Бүгд: 67
59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 22.5 дахь хэсгийн, мөн зүйлийн тайлбарын “зохиогч,” гэснийг, мөн зүйлийн 22.4.4 дэх заалтын “шинжлэх,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 25
Бүгд: 67
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “зарим” гэснийг, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийн “эрхийг зохиогч, зохиогчийн” гэснийг “эрхийг энэ хуульд заасан журмын дагуу зохиогчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 28
Бүгд: 67
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “/үүнд тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй/” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар: Энэ хуулийн 28.2.2-т заасан “дамжуулах” гэдэгт тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн

байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 25
Бүгд: 67
62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “болох бөгөөд энэ хуулийн 35, 36, 37 дугаар зүйлийг баримтална.” гэснийг “болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 24
Бүгд: 67
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн, 33.2 дахь хэсгийн “Тоглогч уран бүтээлчийн” гэснийг “Хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 26
Бүгд: 67
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын, 37.1.2 дахь заалтын, 37.2.6 дахь заалтын, 37.3 дахь хэсгийн, 37.4 дэх хэсгийн, 37.6 дахь хэсгийн “зохиогч,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 27
Бүгд: 67
59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.2.3.ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 27
Бүгд: 67
59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28
Бүгд: 67
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмж, мөн хэсгийн “нэг удаа, нэг хувийг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 27
Бүгд: 67
59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “эрхийн” гэснийг “эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 29
Бүгд: 67
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 27
Бүгд: 67
59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалтын “бусад” гэсний дараа “шаардлагатай” гэж нэмж, мөн зүйлийн 47.2.7 дахь заалтын “төлөвлөгөө /орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна/.” гэснийг “төлөвлөгөөнд орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 47.5 дахь хэсэг нэмэх:

“47.5.Энэ хуулийн 47.1.5-д заасан сургалтыг оюуны өмчийн байгууллага болон түүнээс эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна. Сургалт зохион байгуулах журмыг оюуны өмчийн байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 29
Бүгд: 67
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын дугаарыг “48.1.1” гэж, 48.1.3 дахь заалтын “авсан” гэснийг “энэ хуулийн 48.1.1-д заасан” гэж, 48.1.4 дэх заалтын “оюуны

өмчийн” гэснийг “холбогдох” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 48.5.1, 48.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.5.1.зохиогчийн эрх, хамаарах эрхийн төрөл, ангилал тус бүрд цуглуулсан төлбөрийн мэдээлэл, гишүүдэд хуваарилсан төлбөрийн дүн, захиргааны зардал болон төлөгдөөгүй бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн талаарх тухайн жилийн санхүүгийн мэдээлэл;

48.5.2.тухайн жилд хамтын удирдлагын байгууллагын байгуулсан лицензийн гэрээний тоо, үнийн дүн, гэрээний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй тайлан,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 29

Бүгд: 67

56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.4 дэх заалтын “өөрчлөлтийг” гэсний дараа “эрх бүхий этгээд, гишүүдэд” гэж, мөн зүйлийн 49.6 дахь хэсгийн “ашиглалтын” гэсний дараа “батлагдсан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 49.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 26

Бүгд: 67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.3.4 дэх заалтын “даалгаврыг” гэсний дараа “хугацаанд нь” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 27

Бүгд: 67

59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “баталгаажуулах,” гэсний дараа “төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж, мөн зүйлийн 51.4 дэх хэсгийн “хуралдаан байна.” гэсний дараа “Зөвлөлийг нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 27

Бүгд: 67

59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.7, 51.8 дахь хэсэг нэмэх:

“51.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.8.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28

Бүгд: 67

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “зохиогч,” гэснийг хасаж, мөн зүйлийн 52.1 дэх хэсгийн “зохиогч болон эрх” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах эрх” гэж, мөн зүйлийн 52.4 дэх хэсгийн “зохиогч,” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах” гэж, мөн зүйлийн 52.6 дахь хэсгийн “онцгой эрхийг авсан этгээд гэрээнд заасан бол” гэснийг “этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа бол” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 29

Бүгд: 67

56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 57 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 57.1 дэх хэсгийн “эрх болон түүнд хамаарах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28

Бүгд: 67

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 58 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн” гэсний дараа “үеийн” гэж нэмж, мөн зүйлийн 58.1, 58.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 58.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58.1 дэх хэсэг болгох:

“58.1.Хамтын удирдлагын байгууллагын хувьд энэ хуулийн 49.4-т заасан хязгаарлалт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 27

Бүгд: 67

59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томъёолол:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “харилцааг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын “хэлбэрийг” гэснийг “хуулбарыг” гэж, мөн заалтын “, түүнчлэн уг” гэснийг “болон эдгээр” гэж, мөн зүйлийн 4.1.22 дахь заалтын “хэлбэрийн” гэснийг “хуулбарын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “байдаг” гэснийг “байрладаг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “түүний” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 12.1.4 дэх заалтын “түүний” гэснийг “бүтээлийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, мөн хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн, 21.4 дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “энэ хуулийн” гэснийг “энэ хуульд заасны” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зөрчихгүй” гэснийг “зөрчихгүй байх үүрэгтэй” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “болон” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 35.4 дэх хэсгийн “олгохтой холбоотой” гэснийг “олгох” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.2 дахь заалтын “эрхүүд” гэснийг “эрх” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “сонинд” гэснийг “сонин, сэтгүүлд” гэж, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “ашгийн төлөө бус байгууллага, эсхүл эдгээрийн” гэснийг “эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын” гэж, 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалтын “үрэгдэж алга болсон” гэснийг, 42.1.3 дахь заалтын “устаж алга болсон” гэснийг “устаж үрэгдсэн” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.5 дахь заалтын “эзэмшигчдийн” гэснийг “эзэмшигчийн” гэж, мөн заалтын “хамгаалахаар” гэснийг “хамгаалах асуудлаар” гэж, 48.1.6 дахь заалтын “орны” гэснийг “улсын” гэж, 50 дугаар зүйлийн 50.3.3 дахь заалтын “мэдээг” гэснийг “мэдээллийг” гэж, мөн зүйлийн 50.5 дахь хэсгийн “байгууллагын” гэснийг “байгууллагатай” гэж, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийн “нь” гэснийг “зохицуулалт” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “өв залгамжлагч байхгүй” гэснийг “өв залгамжлагчгүй” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 32
Бүгд: 67
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “эсхүл” гэснийг, мөн зүйлийн 4.1.29 дэх заалтын “талаарх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “бусад” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “болсон” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хувьд” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Энэ” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтын “болсон” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “тэдэнд” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын “зөвхөн” гэснийг, 47.1.5 дахь заалтын “холбогдох” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 54.1 дэх хэсгийн, 54.2 дахь хэсгийн “талаарх” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.1.6 дахь заалтын “энэ” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 26
Бүгд: 67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “эрхийн” гэсний дараа “тухай” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, эсхүл” гэсний дараа “зохиогчийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “эзэмшигчийн” гэсний дараа “эрх,” гэж, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дахь заалтын “эрх болон” гэсний дараа “хамаарах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн, 57 дугаар зүйлийн гарчгийн “эрхийн” гэсний дараа “тухай” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 26

Бүгд: 67

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Т.Аюурсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.5 дахь хэсгийн “бүртгэл хийх” гэснийг “сайн дурын бүртгэл хөтлөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28

Бүгд: 67

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “эрх болон түүнд хамаарах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28

Бүгд: 67

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “өөрчлөлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 28

Бүгд: 67
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 29
Бүгд: 67
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 17 минут үргэлжилж, 13 цаг 17 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 15 минутад эхлэв.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Хоёр.Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Аюурсайхан даргаа та хурал удирдчих.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгээр ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан.

Байнгын хороо 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, зохиогчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор зохиогч өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах эд хөрөнгийн онцгой эрх эдлэх эрхтэй байх, бүтээл ашиглах онцгой эрхийн эрх залгамжлагч нь тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй байх, гэрэл зургийн уран бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх, бүтээлийн зүй ёсны ашиглалтыг нь зөрчихгүйгээр, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр ашигласан бүтээлийн ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх, Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр оюуны өмчийн байгууллагад зөвлөх, бүтээл ашиглалтын тарифыг хянан баталгаажуулах, төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл

байх зэрэг зарчмын зөрүүтэй 28 санал болон найруулгын шинжтэй 3 саналыг ажлын хэсгээс гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Түүнчлэн ажлын хэсгээс Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 4 санал боловсруулсныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгох, зохиогчийн эрхийг түрээслүүлэх гэдэгт эзэмших бус ашиглах эрхийн тодорхой хугацаагаар бусдад шилжүүлэхийг ойлгоно гэж. Түүнчлэн ардын урлагийн бүтээлд тулгуурлан төрөөс үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг үүсмэл бүтээл туурвисан зохиогч эдлэх зохицуулалтыг нэмэх гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Т.Аюурсайхан: Ажлын хэсгийг танилцуулъя. Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сайнзориг мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Энхсүх Оюуны өмчийн газрын дарга, Ганзориг Оюуны өмчийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ мөн газрын Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга, Урангэрэл мөн газрын Аж үйлдвэрийн өмчийн эрх зүйн хэлтсийн дарга, Тамир Монголын оюуны өмч хамгаалах холбооны гүйцэтгэх захирал, Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Амармөрөн мөн яамны мөн газрын ахлах мэргэжилтэн, Эрдэнэчимэг Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал. Одгэрэл Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч. Нэргүй Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн гэсэн ажлын хэсэг цахимаар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байвал нэрээ өгье. Нэрийг тасаллаа. Цахимаар хүн байна уу? Та нар яриагаа болиод авах үед нь анхааралтай нэрээ өг л дөө. Зарчмын зөрүүтэй санал дээр үгээ хэлж болно. Цахимаар нэрээ өг. Байна уу? Байхгүй юу, хэн юм бэ? Нэрсийг нь өгчих. Цахимаар нэрээ аваад дууссан, танхимын нэр аваад дууссан байна. Одоо үгээ өгөх гэж байна. Одоо харин дууссан тасалсан хойно орохгүй шүү дээ. Хоорондоо юм ярьж байхын оронд эндээ нэрээ оруул л даа. Би мэдэхгүй

байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үдээс өмнө энэ цар тахалтай холбоотой асуудал дээр Их Хурал онцгой анхаарах чиглэлээр үүрэг чиглэл өгөөд ингээд маргааш ярилцахаар байна. Энд Улсын онцгой комисс, Засгийн газар, Нийслэлийн онцгой комисс энэ холбогдох байгууллагууд нь нэлээн сайн бэлтгэлийг хангах байлгүй дээ. Нэлээн ярих асуудлууд байна шүү гэж би эхэнд нь хэлье.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Надад нэг хэдэн асуулт байна. 1 дүгээрт бол энэ 8 дугаар бүлэг дээр зохиогчийн эрхийг хамгаалах зохиогчийн эрх зөрчигчид хүлээлгэх хариуцлага гээд ингээд бүхэл бүтэн бүлэг байж байгаа. Энэ зохиогчийн эрхийн хууль маань бол 93 онд батлагдаад хамгийн сүүлд 2016 онд шинэчилсэн найруулгаар баталсан. Үүнээс хойш одоо энэ 15 жилийн хугацаанд энэ зохиогчийн эрхийг зөрчсөн этгээдүүдэд ямар хариуцлага оногдуулсан бэ, энэ талаар одоо бүх төрлөөр нь судалгаа нарийвчилсан судалгаа гаргасан ийм зүйлүүд байна уу? Энэ талаар маш их хэл ам гардаг учраас би энэ асуултыг зориуд тавьж байгаа юм.

Одоо энэ шинэ хуулийн төсөлд ч гэсэн зохиогчийн эрх зөрчсөн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагатай холбоотой асуудал бас өмнөх хуулиуд шигээ одоо нэг тунхгийн шинж чанартай ийм зүйлүүд болоод өнгөрөх үү? Үүнтэй холбоотойгоор цаашлаад асуух асуулт бол байцаагч улсын байцаагч оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ноогдуулна гэж байгаа юм. Энэ одоо улсын байцаагчийн эрх мэдлийн хүрээ гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхой болгож хуульд оруулах чиглэлээр ямар ажил зохион байгуулсан бэ? Ийм зүйлийг асуумаар байгаа юм. IT чиглэлийн энэ компьютерын программ хангамжтай холбоотой, компьютерын программ хангамжийн эрхтэй холбоотой ийм асуудлууд байгаа. Энэ цаг нь багтахгүй учраас 1 минут маань нэмэгдэж байгаа юу, нэмэгдээгүй байна уу?

Т.Аюурсайхан: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Бат-Эрдэнэ: Үүнтэй холбоотойгоор би 2 асуудал асуугаад орхиё. 3 дугаар бүлэг 19.2, 22.3 дугаар заалтууд байгаа. Ажил гүйцэтгэгчийн зохиосон бүтээлийг ажил олгогчдод мэдэгдэлгүйгээр өөрөө ашиглах эсхүл гуравдагч этгээдэл шилжүүлснийг яаж тогтоох юм бэ? Энд программыг зөвшөөрөлгүй ашигласан хөгжүүлэгчид ямар аргаар яаж хариуцлага тооцох юм бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Нөгөө нэг юм бол энэ мэдээллийн сантай холбоотой. Бүртгэлийн нэгдсэн бүртгэлийн тогтолцоотой холбоотой ийм асуудлууд байж байгаа юм. Дундаа байгуулсан мэдээллийн сангийн эрх зүйн зохицуулалтыг энд оруулж болох юм уу? Болох уу энэ талаар нэг тодорхой хариулт өгөөч. Нөгөө нэг зүйл бол хуулийг боловсруулахдаа зохиогчийн бүтээлийн нэгдсэн санг байгуулах талаар ярилцсан судалсан сантай холбогдох шинээр одоо заалт оруулах энэ асуудлыг үзсэн ийм зүйлүүд байна уу?

Т.Аюурсайхан: Мөнхцэцэг гишүүн хариулъя. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ зохиогчийн эрхийн тухай хууль нь 2006 онд шинэчилсэн найруулагдаад тэрнээс хойш одоо бараг 15, 16 жил өнгөрсөн. Энэ хугацаанд бол гол нь технологийн дэвшил, Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн тэр мэдээллийн технологийн хэрэглээ бол асар өргөжсөн. Үүнтэй уялдаад яах аргагүй

энэ зохиогчийн эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүй гэдэг юм уу эсхүл одоо хулгайн замаар хуулбарлах олшруулах интернэт орчинд байршуулах ажиллагаа бол маш түгээмэл байгаа. Тийм учраас яг энэ хууль дээр маань мэдээллийн сангийн зохиогчийн эрх гэж энэ тусгай 23 дугаар бүлгийг бол оруулсан байгаа.

Энэ дээр бол тэр мэдээллийн санд сан үүсгэсэн этгээд зохиогчийн эрх эзэмшигч нь энэ мэдээллийн сангийн дагуу эрхээ хамгаалуулах эсхүл тухайн мэдээллийн санд орсон бүтээлүүдээ зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу тухайн этгээдэд зөрчил оноох тухай асуудлыг бол сайн оруулж өгсөн байгаа. Тэгээд ер нь бол мэдээллийн сангийн нийтийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагын болон шүүхийн ажиллагаанд ашиг зорилгоор ажилласан хөгжүүлсэн зэрэг нийтэд зориулагдсан үйл ажиллагааг бол зөрчил гэж тооцохгүй байгаа. Үүнээс бусад нөгөө мэдээллийн санд оруулсан эрхүүдийг бол хамгаалж байгаа. Тэгээд тэр эхний асуултын хувьд бол энэ зохиогчийн эрхийн тухай хуулийн зөрчил буюу бусдын бүтээлийг ашигласан тохиолдолд эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиар хариуцлага ноогдуулна. Энэ маань тэр хуулиуд дээр бол мөнгөн торгууль байгаа. Мөн одоо тухайн хууль зөрчиж олсон ашиг орлогыг бол хурааж авах. Хуулийг этгээдийг бол 5 сая хүртэл, хувь иргэнийг бол 500 мянган төгрөгөөр торгох зэрэг ийм шийтгэлүүд бол байгаа.

Тэгээд ер нь энэ зохиогчийн эрхийн тухай шинэ хуулийн яг гол онцлог бол энэ ерөөсөө мэдээллийн технологи болон энэ сүүлийн 10 хэдэн жилийн одоо олон улсын хамтын ажиллагаа, улсууд хоорондын харилцааны улбаатайгаар Монголын бүтээлүүдийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэх оюуны өмчийг баталгаажуулах олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх зэрэг ийм зорилгоор хуулиуд бол тодорхой төслүүд орж ирсэн байгаа. Тэгээд манай ажлын хэсгээс тухайлан асуусан 3.19 зэрэг заалтууд дээр бас хариулт нэмж өгөх хэрэгтэй байна. Сайнзориг байна уу хэн, ажлын хэсгийн гишүүдээс энэ дээр бас тодорхой заалтууд дээр нэмж хариулт өгнө.

Т.Аюурсайхан: Байнгын хорооны санал, дүгнэлтээс асууж байгаа шүү. Байнгын хорооны санал, дүгнэлтээс асууж байна. Одоо Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна.

Ч.Ундрам: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ зохиогчийн эрхийн тухай хууль орж ирж байгаад маш их баяртай байгаа. Ерөнхийд нь хуулийг бол дэмжиж байгаа. Тэгэхээр Монгол Улсад 2020 оны байдлаар оюуны өмчтэй холбогдох нийт зөрчлийн 65-70 хувь зохиогчийн эрхийн зөрчил байдаг. Тэгэхээр зохиогчийн эрхийг хөндсөн энэ зөрчилд хүлээлгэх хариуцлагыг мөн зохиогчид учирсан хохирлыг тооцох асуудлыг илүү нарийвчилж оруулсан уу энэ анхны хэлэлцүүлэгт бэлтгэх явцдаа ажлын хэсэг гэж 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт сая бас Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Энэ IT-тай холбоотой гэж байна. Тэгэхээр төслийн 5 дугаар зүйлийн 5.1-т агуулга зориулалт үнэ цэнэ ач холбогдол илэрхийллийн аргаасаа үл шалтгаална. Зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан утга зохиол урлагийн бүтээлийг зохиогчийн эрхийн бүтээлд тооцно гэсэн заалтад компьютерын программ, мэдээллийн сан гэж бас нэмж оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Дээрээс нь энэ боловсролын байгууллага одоо ялангуяа их, дээд сургуулиудад бол ... маш их явагддаг байгаад байгаа юм Монгол Улсад. Нэг нэгнийхээ магистр, докторын дипломыг энд тэндээс олж авч хуулах, тэндээс нь бүхэл бүтэн бүлгийг нь хуулаад авсан байдаг ч юм уу. Дээрээс нь Монголд хийгдсэн судалгааг аваачиж гадаад

улсад орчуулаад хамгаалах гэдэг ч юм уу ийм асуудлууд маш ихээр гардаг. Тэгэхээр энэтэй холбоотой ямар зүйл заалтууд орсон бэ гэсэн ийм 3 асуулт байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг хариулъя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Ундрэм гишүүний асуулт бол маш чухал асуулт. Ер нь бол оюуны өмчийн зөрчил зөвхөн одоо аж үйлдвэрийн салбарт гэхээсээ илүү бас ийм оюун ухааны судалгаа шинжилгээ эрдэм шинжилгээний салбарт маш түгээмэл байдаг. Тухайлбал энэ эрдэмтдийн ном бүтээлийг хуулбарлах олшруулах эсхүл өөрийн нэр тавин өөрийн бүтээл мэт хэрэглэн хэвлэх зэрэг явдлууд маш түгээмэл байгаа. Тийм учраас энэ хууль дээр энэ зохиогчийн энэ эрдэм шинжилгээний бүтээлийг ямар үед хамгаалах вэ? Ямар үед нийтийн өмч гэдгээр задлан ялгах вэ гэдэг дээр тодорхой заалтууд оруулсан байгаа.

Тухайлбал энэ зохиогч маань тухайн эрдэм шинжилгээний бүтээл байна уу эсхүл тухайн их сургуульд жишээлэл тухайн бүтээл хэн нэгний ном байна уу эсхүл диссертац зохиогчийн эрхийн зөрчилтэй гэж үзсэн байх магадлалтай бол оюуны өмчийн газар болон эсхүл зохиогчийн хамтын удирдлагын байгууллагуудад хандаж энийг магадлуулах боломжтой. Өөрөөр хэлбэл докторын зэрэг байна уу ямар нэгэн зэрэг хамгаалахдаа тухайн бүтээлийг эх сурвалжгүйгээр эсхүл зохиогчоос зөвшөөрөл аваагүйгээр оюуны өмчийн зөрчил байдлаар хэрэглэсэн бол их сургуулийн зөвлөл гэдэг юм уу эсхүл их сургууль гэдэг юм уу тухайн багш нар маань энэ хамтын эрхийн байгууллага руу хандах боломжтой байгаа.

Харин тухайн бүтээлийг ямар үед зохиогчийн эрхийн зөрчлийг үүсгээгүй гэж үзэх вэ гэхээр дараах тохиолдол орж байна. Жишээлбэл энэ бүтээлийн зүйл ёсны ашиглалтыг зөрчихгүйгээр зохиогчийн эзэмших эрх хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр ашигласан дараах бүтээлүүдийг бол энэ 38 дугаар зүйл дээр бид нар оюуны өмчийн зөрчил гэж тооцохгүй байгаа. Жишээлбэл эрдэм шинжилгээ судалгаа сургалт шүүмж бичих зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах гэж байгаа юм. Энэ дээр бол тухайн судлаач гэдэг юм уу шинэ залуу судлаач маань анх бүтээсэн зохиолчийнхоо нэрийг дурдаад явах ёстой. Энэ тохиолдолд бол энийг зохиогчийн эрхийн зөрчил гэж үзэхгүй. Дээрээс нь.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Хуулийн хэлэлцэх эсэх дээр бол ажлын хэсгийн гишүүд хууль санаачлагч эд нар хариулбал зохих асуултууд бас явж байна. Энэ анхны хэлэлцүүлэг явсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж байгаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэг асуулт асууна.

Г.Мөнхцэцэг: Сонсогдож байна уу даргаа?

Т.Аюурсайхан: Асуултаа асуугаарай дуу орж ирэхгүй байна. Микрофоноо нээгээрэй та.

Г.Мөнхцэцэг: Микрофон нээлттэй байгаа юм.

Т.Аюурсайхан: Одоо болж байна. Цагийг нь шинээр.

Г.Мөнхцэцэг: Та бүхний амрыг айлтгая. Тэгэхээр энэ зохиогчийн эрхийн тухай хууль бол үнэхээр бас цаг үеэ олсон бас онцгой шаардлагатай байгаа энэ

хууль гэж би бас ингэж үзэж байгаа. Монгол Улс бол Үндсэн хуульдаа зохиогчийн эрх бол үндэсний баялаг гээд ингээд тодорхой болгоод зохиогчийн өмч бол үндэсний баялаг гээд ингээд бүр маш том тодорхойлолтыг бол хэлээд өгсөн ийм байгаа. Ийм учраас бол энэ цаг үеэ олсон ийм хууль явж байна гэж ингэж ойлгож байгаа юм. Тэгэхээр жилд 1000 гаруй бүтээл зохиогчийн эрх авдаг байгаа юм. Түүний бараг 100 гаруй зохиогчийн эрхийн зөрчил бүртгэгддэг байгаад байгаа.

Тэгэхээр үндсэндээ бол энэ нь 65 хувь нь бол зөрчилтэй байгаад байна гэсэн үг. Тэгэхээр энэ хуулийн хэлэлцүүлэг явагдаж байх үед одоо утга зохиол урлаг соёлын салбарынхан бас тодорхой шүүмжүүдийг бас өрнүүлж байсан. Хамгийн гол нь бид нар бүтээлийнхээ эрхийг эзэмших. Мөн дээрээс нь одоо энэ бидний бүтээлийг хуулбарлах энэ тал дээр зохиогч энэ оюуны өмчийн газрынхан бол тодорхой хэмжээний хуулийн дагуу асуудлуудыг бас шийдэж өгөх ёстой гэдэг ийм одоо зүйлүүдийг ярьж байсан. Тэгэхээр ер нь бол хууль бусаар олсон орлогыг нь бол улсын орлого болгочихдог. Гэтэл тэр тухайн уран бүтээлч зохиогч нь бол өөрөө бол хохироод үлддэг ийм явдал бол бас удаа дараа давтагддаг. Ер нь бол энэ зөрчлийн ихэнх нь бол ийм түвшинд явж байдаг.

Тэгэхээр өнгөрсөн жил гэхэд 93 сая төгрөгийн торгууль ноогдуулсан гэсэн ийм тоо баримт байна лээ. Тэгэхээр бол хэчнээн хохирол учирсан юм бэ тэрний хэчнээнийг нь энд жишээгээр барагдуулсан юм бэ гэдэг ийм ойлгомжгүй юмнууд бас байна лээ. Тэгэхээр ер нь бол энэ зохиогч зохиолчийн бүтээлийн үнэлгээний тал дээр ямар зохицуулалтыг энэ хуулиар хийж өгсөн юм бэ шинээр. Хамгийн гол нь бол зохиогчийн бүтээлийн үнэлгээ чухал. Тэгэхээр энэ зохицуулалт ямар байдлаар туссан байгаа вэ гэдэг дээр би 1 дүгээрт хариулт авъя гэж бодсон юм. Мөн энэ хариуцлагыг чангатгах тал дээр илүү ямар байдлаар яах вэ Зөрчлийн хуулиар бол иргэнд бол 500 мянга, дээрээс нь аж ахуйн нэгжийг бол 5 сая төгрөгөөр ингээд торгодог байж байгаа. Тэгэхээр энэ хариуцлагыг чангалах тал дээр ямар заалтууд нэмж орсон бэ гэдэг дээр ийм 2 зүйлийн асуулт байна.

Т.Аюурсайхан: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн хариулъя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ зохиогчийн эрхийн бүтээлийн үнэ цэнийг хадгалах зохиогчийн эрхийн бүтээлийг цаашид дамжуулан худалдсан тохиолдолд тухайн анхдагч зохиогчид өгөх урамшил мөн юуг бол шинээр зохицуулж өгсөн байгаа. Тухайлбал энэ хуулийн 35.3 дээр ингэж байгаа. Зохиогч болон зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхой болсны дараа бүтээлийг төлбөртэй ашиглуулсан бол оюуны өмчийн байгууллага зохиолч зохиогчийн эрх эзэмшигчид төлбөрийн зохих хувийг нөхөж олгоно гэж. Мөн энийг бол тодорхой жишээ дээр татаж оруулсан заалтууд бол байна.

Жишээлбэл энэ уран зураг, уран баримлын бүтээгдэхүүнийг худалдан авсан этгээд дахин худалдаж байгаа тохиолдолд тухайн уран бүтээлийн зохиогчид худалдсан үнийн дүнгийн 5-аас багагүй хувийг төлнө гэж. Өөрөөр хэлбэл зохиогчийн эрхийн дараа дараагийн үнэ цэнийг хадгалсан. Дараагийн бизнес худалдаанаас олох орлогын 5 хүртэл хувийг бол буцааж өгөх байдлаар оруулсан байгаа. Тэгээд мөн энэ кино уран бүтээл гээд бүх салбаруудад тухайн бүтээлд хувь нэмэр оруулсан уран бүтээлчийн нэр зааж тухайн бүтээлчийн эрхийг бол хадгалахаар заалтууд оруулсан байгаа.

Жишээлбэл тухайн кино уран бүтээл гаргасан хувцасны дизайнер гоо сайханч байна уу тэгээд тухайн киноны уран зураг гээд бүх хүмүүс тухайн

киноноос олсон ашиг мөн тухайн киног цаашид давхар хэрэглэх тохиолдолд зохиогчийн эрхийг эзэмшинэ гэх мэтээр иймэрхүү заалтууд бол орсон байгаа.

Т.Аюурсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. 38 санал байна. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын "мэдээллийг" гэсний дараа "хуульд заасны дагуу" гэж нэмж, мөн зүйлийн 4.1.13 дахь заалтын "энэ хуулийн 4.1.7-д заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх этгээдийг /Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4,1.5-д заасан радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийг;" гэснийг, мөн зүйлийн 4.1.27 дахь заалтын хиймэл дагуул" гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4.1.28 дахь заалтын "зохиогч, эрх эзэмшигчийн" гэснийг "зохиогч, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн" гэж өөрчлөх, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг, Пүрэвдорж, Сандаг-Очир, Цогтбаатар, Бямбасүрэнгийн Энх-Амгалан цаашид ажлын хэсэг гэх. Төхөөрөмжийнхөө санал байгаа юм уу, зөвхөн уг заалттай холбогдуулж саналаа хэлнэ шүү. Туваан гишүүнд микрофон өгье.

Ц.Туваан: Ер нь үг хэлэхэд ч хэцүү болж байна даа. Зохиогчийн эрхийн тухай хууль чухал хууль. Энэ хуулийг төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Энэ бол хуультай журамтайгаа явах ёстой. Дээрээс нь Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар Улсын Их Хурлын Монгол ардын намын нэр бүхий Мөнх-Оргил нарын гишүүд илт худал мэдэгдэл хийж байгаа учраас энийг залруулж бас нэг өгүүлбэр хэлье. Америкийн ямар юм.../үг тасрав/

Т.Аюурсайхан: Энэ саяын зарчмын зөрүүтэй заалтыг дэмжсэн, эс дэмжсэн үг хэлж болно. Тэр өөр бусад асуудлаар энэ мэдээллийн цаг байгаа. Бусад арга хэлбэрээр олон нийтэд залруулгаа та хийж болно. Төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж туршилтын санал хураалт явуулъя. Ирцэд байгаа гишүүд тийм гэсэн товчлуураа дарна уу. Санал хураалт туршилтын. Техникийнхэн техникийн бэлэн байдал, сүлжээний саатлыг шалгаарай, орохгүй байна уу? Төхөөрөмжөө бэлэн байдалд оруулаарай. Техникийн хэлтсийнхэн болж байна уу, дахиж явуулах уу? Ирцэд байгаа гишүүд шалгахын тулд төхөөрөмжөө шалгахын тулд тийм дээр дарна уу. Дахиад туршилтын санал хураалт дахин явуулъя. Санал хураалт явуулъя. 1 дүгээр санал хураалт. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал санал хураалт явуулъя. Томъёоллыг нь уншсан байгаа. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56,7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтын "эзэмших" гэснийг "ашиглах" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 57,6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"7.1.2.төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн шийдвэр, албан бичиг;" санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “энэ хуулийн дагуу” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтын “нэгдэн орсон олон улсын гэрээний гишүүн улс, эсхүл Монгол Улстай уг асуудлаар хоёрт талт олон улсын гэрээ байгуулсан” гэснийг “олон улсын гэрээний гишүүн” гэж, 8.1.5 дахь заалтын “тус” гэснийг “Монгол” гэж тус тус өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Бүтээл ашиглах” гэснийг “Зохиогчийн эд хөрөнгийн” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.1 дэх хэсэг нэмэх:

“13.1.Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах эд хөрөнгийн онцгой эрх /цаашид “бүтээл ашиглах онцгой эрх” гэнэ/ эдэлнэ.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 13.2 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1-д” гэснийг “13.2-т” гэж өөрчлөх.

“13.2.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд дараах эрхийг хамааруулна:” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

14 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа

“14.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан, эсхүл нийтэлсэн өдрөөс эхлэн тооцно.

14.2.Зохиогчийн амины эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална.

14.3.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.4.Хавсарга урлагийн бүтээл ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвиснаас хойш 25 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.5.Зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан бүтээлийн зохиогч нь өөрийгөө ил болгосон, эсхүл бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг энэ хуулийн 14.3-т зааснаар тооцно.

14.7.Хамтын бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.

14.8.Албан үүргийн дагуу бүтээл туурвих, эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна. Хэрэв бүтээлийг туурвиснаас хойш 30 жилийн хугацаанд нийтлээгүй бол бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл туурвиснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 60,6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хасаж, 14.6 дахь хэсгийн “14.5-д” гэснийг “14.4-т” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг, санал хураалтыг түдгэлзүүлье. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Ингээд сая Улсын Их Хурлын гишүүн Бямбацогтын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 7 дахь хэсэг дэмжигдсэн учраас зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 8 дахь хэсэг, мөн найруулгын 1 дэх саналын 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн хамгаалагдана гэснийг хүчин төгөлдөр байна гэснийг мөн 2 дахь саналын 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн болох нь гэснийг тус тус ажлын хэсгээс татан авч байна.

Т.Аюурсайхан: Нэг нь түрүүчийн санал хураасан юу?

Ц.Мөнхцэцэг: Үгүй одоо энэ 8. 8 татаад тэгээд найруулга дээр 2, 3 санал. Тийм одоо 8 дугаар зүйл зарчмын зөрүүтэй 8-аа татан аваад дахиад найруулга дээр энэ 2, 3 саналаа татан авлаа.

Т.Аюурсайхан: 8 дугаар саналыг санал гаргасан ажлын хэсэг татаж авч байна. Цаашаа явъя. Та найруулга дээр дахиад хэлээрэй найруулгын санал эхлэхээр Мөнхцэцэг гишүүнээ.

9.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 15.6 дахь хэсгийг 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн хэсгийн “15.5-д” гэснийг “15.6-д” гэж өөрчлөх.

“15.5.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн эрх залгамжлагч тухайн зохиогчийн бүтээлийг гуйвуулах, гажуудуулах байдлаар өөрчлөх, түүнчлэн зохиогчийн нэр төрд хохирол учруулахуйц байдлаар ашиглахыг эсэргүүцэх эрхтэй.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.1.Энэ хуулийн 13.2-т заасан эрхийг хуульд заасан болон бичгээр хийсэн гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлнэ.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.4 дэх хэсгийг нэмэх:

“17.4.Ардын урлагийн бүтээлд тулгуурлан туурвисан үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийг үүсмэл бүтээл туурвисан зохиогч эдэлнэ.” санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “, эсхүл захиалагч” гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 22.5 дахь хэсгийн, мөн зүйлийн тайлбарын “зохиогч,” гэснийг, мөн зүйлийн 22.4.4 дэх заалтын “шинжлэх,” гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “зарим” гэснийг, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийн “эрхийг зохиогч, зохиогчийн” гэснийг “эрхийг энэ хуульд заасан журмын дагуу зохиогчийн” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын “/үүнд тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй/” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар: Энэ хуулийн 28.2.2-т заасан “дамжуулах” гэдэгт тоглогч уран бүтээлчийн зөвшөөрлөөр түүний тоглолтын бичлэгийг өргөн нэвтрүүлэх, эсхүл нийтэд дамжуулах, тоглолтыг анх шууд өргөн нэвтрүүлсэн өргөн нэвтрүүлгийн байгууллагын зөвшөөрлөөр нэгэн зэрэг дамжуулах хамаарахгүй.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 62.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “болох бөгөөд энэ хуулийн 35, 36, 37 дугаар зүйлийг баримтална” гэснийг “болно.” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн, 33.2 дахь хэсгийн “Тоглогч уран бүтээлчийн” гэснийг “Хамаарах эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ. 19 үү одоо?

18.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын, 37.1.2 дахь заалтын, 37.2.6 дахь заалтын, 37.3 дахь хэсгийн, 37.4 дэх хэсгийн, 37.6 дахь хэсгийн “зохиогч,” гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 38 дугаар зүйлийн 38.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.2.3.ашигласан хэсгийн хэмжээ нь зорилгоосоо хэтрэхгүй байх;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмж, мөн хэсгийн “нэг удаа, нэг хувийг” гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “эрхийн” гэснийг “эрх эзэмшигчийн” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх эзэмшигчийн” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалтын “бусад” гэсний дараа “шаардлагатай” гэж нэмж, мөн зүйлийн 47.2.7 дахь заалтын “төлөвлөгөө /орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна/.” гэснийг “төлөвлөгөөнд орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц зэргийг хамааруулна.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 47.5 дахь хэсэг нэмэх:

“47.5.Энэ хуулийн 47.1.5-д заасан сургалтыг оюуны өмчийн байгууллага болон түүнээс эрх олгосон хуулийн этгээд зохион байгуулна. Сургалт зохион байгуулах журмыг оюуны өмчийн байгууллагын дарга батална.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 49.1.2 дахь заалтын дугаарыг “48.1.1” гэж, 48.1.3 дахь заалтын “авсан” гэснийг “энэ хуулийн 48.1.1-д заасан” гэж, 48.1.4 дэх заалтын “оюуны өмчийн” гэснийг “холбогдох” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 48.5.1, 48.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.5.1.зохиогчийн эрх, хамаарах эрхийн төрөл, ангилал тус бүрт цуглуулсан төлбөрийн мэдээлэл, гишүүдэд хуваарилсан төлбөрийн дүн, захиргааны зардал болон төлөгдөөгүй бүтээл ашиглалтын төлбөрийн дүнгийн талаарх тухайн жилийн санхүүгийн мэдээлэл;”

“48.5.2.тухайн жилд хамтын удирдлагын байгууллагын байгуулсан лицензийн гэрээний тоо, үнийн дүн, гэрээний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй тайлан;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56.17 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1.4 дэх заалтын “өөрчлөлтийг” гэсний дараа “эрх бүхий этгээд, гишүүдэд” гэж, мөн зүйлийн 49.6 дахь хэсгийн “ашиглалтын” гэсний дараа “батлагдсан” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 49.5 дахь хэсгийг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Төслийн 50 дугаар зүйлийн 50.3.4 дэх заалтын “даалгаврыг” гэсний дараа “хугацаанд нь” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “баталгаажуулах,” гэсний дараа “төлбөр төлөх, хуваарилахтай холбоотой гомдлыг урьдчилан шийдвэрлэх” гэж, мөн зүйлийн 51.4 дэх хэсгийн “хуралдаан байна.” гэсний дараа “Зөвлөлийг нийт гишүүдийн дийлэнх олонхын ирцтэйгээр хуралдуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.” гэж тус тус нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.7, 51.8 дахь хэсэг нэмэх:

“51.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, гомдлыг урьдчилан шийдвэрлэх, бүтээл ашиглалтын тариф батлах болон бусад үйл ажиллагаанд баримтлах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

51.8.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Төслийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “зохиогч,” гэснийг хасаж, мөн зүйлийн 52.1 дэх хэсгийн “зохиогч болон эрх” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах эрх” гэж, мөн зүйлийн 52.4 дэх хэсгийн “зохиогч,” гэснийг “зохиогчийн эрх болон хамаарах” гэж, мөн зүйлийн 52.6 дахь хэсгийн “онцгой эрхийг авсан этгээд гэрээнд заасан бол” гэснийг “этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа бол” гэж тус тус өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Төслийн 57 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 57.1 дэх хэсгийн “эрх болон түүнд, хамаарах” гэснийг хасах, түүнд гэгчхээд таслалтай байх ёстой юу? За санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Төслийн 58 дугаар зүйлийн гарчгийн “Шилжилтийн” гэсний дараа “үеийн” гэж нэмж, мөн зүйлийн 58.1, 58.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 58.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 58.1 дэх хэсэг болгох:

“58.1.Хамтын удирдлагын байгууллагын хувьд энэ хуулийн 49.4-т заасан хязгаарлалт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хамаарахгүй.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт явуулаарай. Санал хураалтад 67 гишүүн оролцож 59.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын саналыг уншина. Найруулгын санал дээр ажлын хэсэг, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Энэ найруулгын саналын 1 дүгээр санал дээр 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн хамгаалагдана гэснийг хүчин төгөлдөр байна гэж гэснийг татан авч байгаа ажлын хэсгээс.

Т.Аюурсайхан: Түр хүлээгээрэй. 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн хамгаалагдана гэснийг хүчин төгөлдөр байна гэж гэснийг татан авч байна. Өөр?

Ц.Мөнхцэцэг: 2 дахь саналын 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн болох нь гэснийг ажлын хэсгээс мөн татан авч байна.

Т.Аюурсайхан: За. Өөр?

Ц.Мөнхцэцэг: Болсон. Энэ 2 санал.

Т.Аюурсайхан: Ойлголоо. 2 томъёоллыг ажлын хэсгээс татан авч байгаа тул бусад саналыг санал хураалгахаар танилцуулъя. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “асуудлыг” гэснийг “харилцааг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын “хэлбэрийг” гэснийг “хуулбарыг” гэж, мөн заалтын “, түүнчлэн уг” гэснийг “болон эдгээр” гэж, мөн зүйлийн 4.1.22 дахь заалтын “хэлбэрийн” гэснийг “хуулбарын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “байдаг” гэснийг “байрладаг” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “түүний” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 12.1.4 дэх заалтын “түүний” гэснийг “бүтээлийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, мөн хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн, 21.4 дэх хэсгийн “бүтээлийг” гэснийг “бүтээл” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “энэ хуулийн” гэснийг “энэ хуульд заасны” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зөрчихгүй” гэснийг “зөрчихгүй байх үүрэгтэй” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “зүйлийн” гэснийг “хуулийн” гэж, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийн “болон” гэснийг “зохиогчийн” гэж, мөн зүйлийн 35.4 дэх хэсгийн “олгохтой холбоотой” гэснийг “олгох” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.2 дахь заалтын “эрхүүд” гэснийг “эрх” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “сонинд” гэснийг “сонин, сэтгүүлд” гэж, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “ашгийн төлөө бус байгууллага, эсхүл эдгээрийн” гэснийг “эрх бүхий байгууллага, эсхүл дээрх байгууллагын” гэж, 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалтын “үрэгдэж алга болсон” гэснийг, 42.1.3 дахь заалтын “устаж алга болсон” гэснийг “устаж үрэгдсэн” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.5 дахь заалтын “эзэмшигчдийн” гэснийг “эзэмшигчийн” гэж, мөн заалтын “хамгаалахаар” гэснийг “хамгаалах асуудлаар” гэж, 48.1.6 дахь заалтын “орны” гэснийг “улсын” гэж, 50 дугаар зүйлийн 50.3.3 дахь заалтын “мэдээ” гэснийг “мэдээллийг” гэж, үсгийн алдаагаа засаарай, мөн зүйлийн 50.5 дахь хэсгийн “байгууллагын” гэснийг “байгууллагатай” гэж, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийн “нь” гэснийг “зохицуулалт” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “өв залгамжлагч байхгүй” гэснийг “өв залгамжлагчгүй” тус тус өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 52.2 хувийн саналаар дэмжигдлээ. Одоо цөөхөн санал үлдсэн гишүүдээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “эсхүл” гэснийг, мөн зүйлийн 4.1.29 дэх заалтын “талаарх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “бусад”

гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “болсон” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хувьд” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн “Энэ” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтын “болсон” гэснийг, 41 дүгээр зүйлийн 41.6 дахь хэсгийн “тэдэнд” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтын “зөвхөн” гэснийг, 47.1.5 дахь заалтын “холбогдох” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 54.1 дэх хэсгийн, 54.2 дахь хэсгийн “талаарх” гэснийг, 56 дугаар зүйлийн 56.1.6 дахь заалтын “энэ” гэснийг тус тус хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Техникийн саатал явлаа. Техник ажилласангүй кноп дарагдсангүй. Санал хураалтыг цуцалж байна. Санал өгөх товчлуур гарч ирсэнгүй. Санал хураалгахад бэлэн үү, техникийнхэн. Бэлэн гэж байна. Санал хураалтыг дахин явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хурааа. Найруулгын 2 дугаар санал. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “эрхийн” гэсний дараа “тухай” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “, эсхүл” гэсний дараа “зохиогчийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “этгээдийн” гэсний дараа “эрх,” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “эзэмшигчийн” гэсний дараа “эрх,” гэж, 49 дүгээр зүйлийн 49.1.3 дахь заалтын “эрх болон” гэсний дараа “хамаарах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “зохиогчийн” гэсний дараа “эрх” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн, 57 дугаар зүйлийн гарчгийн “эрхийн” гэсний дараа “тухай” гэж тус тус нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.5 дахь хэсгийн “бүртгэл хийх” гэснийг “сайн дурын бүртгэл хөтлөх” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.1 дэх заалтын “эрх болон түүнд хамаарах” гэснийг хассугай.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “өөрчлөлт” гэж нэмэх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56.7 хувийн саналаар дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалдаа оръё. 13 цаг өнгөрсөн байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулж байна. Үдээс хойших нэгдсэн хуралдаан 14 цагаас үргэлжилнэ.